



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/686

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны Хуралдааны III/05 дугаар тогтоол, 2023 оны XVII дугаар Хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 17/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, өсвөр үеийнхний эвлэлдэн нэгдэх, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, тэдний дуу хоолойг сонсож, шийдвэр гаргах түвшинд хүргэж, бодлого төлөвлөлтөд тусгах зорилгоор хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудын нэгдсэн чуулганыг зохион байгуулсугай.

2. Чуулганыг зохион байгуулахад шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг Хүүхэд хамгаалалыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын  
29 өдрийн 1/32 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛЫН БАГШ НАРЫН 57 ДАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН "ШИЛДЭГ БАГШ"  
ШАЛГАРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Сургагч багшийн хөлс	8 цаг	200,000	1,600,000

Үүнээс 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг "Хүүхэд хамгаалал"-ыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх.

-----oO-----